

Модуляр дата төв

Хөрөнгө оруулалт
Road show ХК
Хувьцаа IPO Road show
TIER III E-mail Server
Датацентр
Hosting IPO TIER III
Хувьцаа ХК
SSL Үнэт цаас
VPS Вебсайт Mining farm BackUp
Датацентр Модуляр дата төв Вебсайт
ХК E-mail Domain Үнэт цаас
Хувьцаа эзэмшигч IPO
Датацентр Server Модуляр дата төв
Hosting TIER III Хөрөнгө оруулалт
VPS IP Mining farm Domain
ХК Хувьцаа

ЗОГСОЛТГҮЙ ХӨГЖИЖ, АМЖИЛТААРАА ЯЛГАРЪЯ

АЙТҮҮЛС ХК
ҮНЭТ ЦААСНЫ
ТАНИЛЦУУЛГА | 2017

АГУУЛГА

ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХ НӨХЦӨЛ

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагчийн тухай ерөнхий мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл

Хувьцаа эзэмшигч – Ай Си Ти Групп ХХК

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн орчны шинжилгээ

ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хөрвүүлэн эзэмших үнэт цаас

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Компанийн борлуулалтын орлогын өсөлт

ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ

Андеррайтерийн нөхцөл

Оролцсон байгууллагууд

Эрсдлийн хүчин зүйлс



АНХААРАХ МЭДЭЭЛЭЛ

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Үнэт цаас гаргагч:	Айтүүлс ХК
Үйл ажиллагааны чиглэл:	Мэдээллийн технологи
Үнэт цаасны нэр:	MSE: ITLS
Нийт хувьцааны тоо:	34,452,124 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцаа:	13,387,980 ширхэг буюу 38.86%
Олон нийтэд санал болгох үнэ:	100.00 төгрөг
Хувьцааг арилжих арга:	Тогтоосон үнээр санал болгох
Татан төвлөрүүлэх хөрөнгө:	1,338,798,000 төгрөг
Татсан хөрөнгийн зарцуулалт:	Дархан хот дахь модуляр дата төвийн парк

MSE: ITLS ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХ НӨХЦӨЛ

Үнэт цаасны захиалгыг зөвхөн нэг тогтсон үнээр буюу 100 төгрөгөөр өгөх ба захиалга нийлүүлэлтээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилна.

- 50.0 сая төгрөг хүртэлх захиалгыг 100 хувь биелүүлнэ.
- 50.0 сая төгрөг хүртэлх захиалга нийлээд нийт дүнгээс давбал 100 хувь биелүүлэх тааз 1.0 сая төгрөг байна.

НЭР ТОМЪЁО

Нэрлэсэн үнэ гэж: Компанийн дүрмэнд тусгагдсан үнийг хэлэх бөгөөд энэ үнэ нь компанийн өнөөгийн үнэ цэнийг илтгэдэггүй. Компани хувьцаагаа нэрлэсэн үнээс нь доогуур үнээр худалдаалахыг хуулиар хориглодог.

Дансны үнэ гэж: компанийн нэгж хувьцааны бодит үнэ цэнийг хэлэх бөгөөд үүнийг компанийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгөөс биет бус хөрөнгө болон нийт өр төлбөрийг хасч, үлдсэн хөрөнгийг компанийн нийт гаргасан хувьцааны тоонд хувааж тооцдог.

Бизнесийн үнэлгээний үнэ гэж: хөндлөнгийн үнэлгээний байгууллагаас үнэт цаас гаргагчийн ирээдүйд олох боломжит орлогыг тооцоолж нийт бизнесийг нь үнэлсэн дүнд үндэслэн тооцсон нэгж хувьцааны үнийг хэлнэ.

Олон нийтэд санал болгох үнэ гэж: үнэт цаас гаргагч болон андеррайтер компанийн зүгээс компанийн дансны үнэ, бизнесийн үнэлгээний үнэ болон зах зээлд худалдаалагдах боломжит үнэ зэргийг харгалзан тогтоосон үнийг

Нэгж хувьцааны үнэ цэнэ	Төгрөг
Нэрлэсэн үнэ	43
Үнэт цаас гаргахаас өмнөх дансны үнэ /2016.12.31 байдлаар/	67.4
Үнэт цаас гаргасны дараах дансны үнэ	79.9
Бизнесийн үнэлгээн дээр үндэслэсэн үнэ	128
Олон нийтэд санал болгохоор тогтсон үнэ	100

MSE:ITLS хувьцааг худалдан авах алхмууд

1. Үнэт цаасны данстай байх /Үнэт цаасны компани дээр нээлгэнэ/
Бүрдүүлэх материал:
 - Иргэний үнэмлэх
 - Данс нээх хураамж
2. Үнэт цаасны дансандаа мөнгөө урьдчилан байршуулах
3. Захиалгаа брокерт өгөх

Лавлах утас:

Стандарт Инвестмент ҮЦК

70114433, 99072694, 99072783, 99065017

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 9 сарын 27-ны өдрийн 173 тоот тогтоолоор компанийн хувьцааг нийтэд санал болгон “хувьцаат компани” болох эрхээ авлаа. Монголын хөрөнгийн зах зээлд мэдээллийн технологийн чиглэлээр гарч буй хувьцаа гэдгээрээ онцлогтой.



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч Айтүүлс ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд програм хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Айтүүлс ХК нь интернэтийн технологид суурилсан дата төв, түүний дагалдах үйлчилгээ болох домэйн нэрийн бүртгэл, онлайнд байршуулах төрөлжсөн үйлчилгээнүүд, и-мэйл зэрэг 30 гаруй төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг цогцоор нь үзүүлдэг.

2015 онд TIER II стандартын шаардлагыг хангасан дата төвийг Улаанбаатар хотод байгуулан, амжилттай ажиллуулж, 2017 оны хагас жилийн байдлаар 4,000 гаруй харилцагчдад давхардсан тоогоор 9,000 гаруй үйлчилгээг үзүүлж байна. 2016 онд компани дата төвийнхээ хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, 100 хувь дотоодод байршдаг БизМэйл нэртэй бизнес и-мэйлийн үйлчилгээг шинээр үзүүлж эхэлсэн.

Үнэт цаас гаргагч нь одоогоор 12 ажилтантай бөгөөд дата төвийн үйлчилгээг 7/24 цагийн турш үзүүлдэг. 2015 онд Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбооноос Айтүүлс ХХК-ийг оны “Шилдэг үйлчилгээ үзүүлэгч” компаниар тодорхойлсон. Зах зээлийн судалгааг явуулахад үнэт цаас гаргагч нь 2016 оны байдлаар дотооддоо хамгийн олон вэбсайт байршуулсан байна. Үнэт цаас гаргагч нь цаашид дата төвийн үйлчилгээгээ тэлж, газарзүйн нөөц байршил болох Дархан хотод олон улсын TIER III стандартыг хангасан Модуляр дата төвийн паркийг байгуулахаар зорин ажиллаж байна.

Айтүүлс ХК-ийн хувьцааг Ай Си Ти групп ХХК нь 100 хувь эзэмшдэг. Ай Си Ти ХХК нь 2013 онд байгуулагдсан ба мэдээлэл технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 100 хувийн эзэмшлийн дөрвөн охин компаниа нэгдмэл удирдлага, бодлогоор ханган ажилладаг.

КОМПАНИЙН ҮНДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


Үйлчилгээ	Тайлбар
Байршуулах үйлчилгээ	Вэбсайт, вэбд суурилсан системүүд, и-мэйл болон зориулалтын сервер, тоног төхөөрөмжүүдийг зориулалтын дата төвд байршуулах үйлчилгээ
Тоног төхөөрөмж, дэд бүтэц түрээслүүлэх үйлчилгээ	Хэрэглэгчид шаардлагатай сервер, тоног төхөөрөмж, дэд бүтцийг түрээслүүлэх үйлчилгээ /өөрийн хэрэгцээнд тохирсон түрээсийн үйлчилгээ авах нь үнэтэй сервер, тоног төхөөрөмж худалдан авч ашигласнаас хямд байдаг/
Нөөцлөлтийн үйлчилгээ	Айтүүлс ХК-ийн үзүүлдэг бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ болон хэрэглэгчийн өөр газарт байршуулсан мэдээллийн системийг нөөцлөн, эрсдлээс сэргийлэх, шаардлагатай үед нөөцийг сэргээн, учирсан эрсдлээс хохирол багатай гарах боломжийг олгодог үйлчилгээ
Дагалдах үйлчилгээ	Айтүүлс ХК-ийн үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг дагалдах бусад үйлчилгээ /SSL, IP address, SiteLock г.м./
Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ	Хэрэглэгчдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үзүүлж буй зөвлөх буюу гүйцэтгэх үйлчилгээ
Сургалт	Харилцагч, хэрэглэгчдэдээ зориулсан хэрэглэгчийг чадавхжуулах, мэдлэг олгох үйлчилгээ
Тусламж	Компаниас үзүүлж буй үйлчилгээг ашиглах үед тулгардаг аливаа бизнесийн болоод техникийн асуудлуудыг шийдвэрлэн өгч, хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

КОМПАНИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СХЕМ






ОДООГИЙН ХАРИЛЦАГЧДЫН БҮТЭЦ




ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагчийн хувьцааг толгой компани буюу Ай Си Ти групп ХХК нь 100 хувь эзэмшдэг ба Ай Си Ти групп ХХК-ийн хувьцааг Ворлд френдс ХХК нь 62.5 хувийн эзэмшдэг бол 37,5 хувийг А.Баттамир эзэмшиж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид ба эзэмшлийн хувь





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ – АЙ СИ ТИ ГРУПП ХХК

Ай Си Ти групп ХХК нь үнэт цаас гаргагчийн толгой компани бөгөөд 2013 оноос мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж, охин компаниудаа нэгдмэл удирдлага, бодлогоор ханган ажиллаж байна.

АЙ СИ ТИ ГРУПП ХХК-ИЙН ОХИН КОМПАНИУД

Үнэт цаас гаргагчийн толгой компани Ай Си Ти групп ХХК нь дөрвөн охин компанитай компанийн нэгдэл юм.



Ай Си Ти групп ХХК-ийн 62.5 хувийг эзэмшдэг Ворлд френдс ХХК нь 2013 онд Улаанбаатар хотноо байгуулагдсан ба барилга зам тээвэр, худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг. Цаашид эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах бүхий л салбарт, ялангуяа мэдлэгт суурилсан өндөр технологийн салбарт хөрөнгө оруулалт хийх стратеги баримтлан ажиллаж байна.

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хувьцаат компанийн шинэ дүрмээр Төлөөлөн удирдах зөвлөлийг томилон ажиллуулахаар тогтоосон байна.

№	Эрх бүхий албан тушаалтнууд	Албан тушаал	Хувьцаа эзэмшдэг эсэх
1	И.Алтантулга	Гүйцэтгэх захирал	үгүй
2	Ц.Цацралгэрэл	Нягтлан бодогч	үгүй



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь 2016 оны 12-р сарын 31-ний өдрийн аудитлагдсан санхүүгийн тайлангаар нийт 1.4 тэрбум төгрөгийн эзэмшигчдийн өмчтэй, 197.8 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй, 18.3 сая төгрөгийн цэвэр ашигтай гарсан. Компанийн санхүүгийн тайлагналыг аккруэл сууриар бүртгэдэг тул нийт өр төлбөрийн 58.6 хувийг урьдчилж орсон орлого бүрдүүлж байгаа нь компанийн өр төлбөрийн эрсдлийн хэмжээг бууруулж байна. Компанийн борлуулалтын орлого жил бүр өсч, 2016 онд 474.9 сая төгрөгт хүрчээ.

Компанийн санхүүгийн байдлын хураангуй тайлан, төгрөг

Үзүүлэлтүүд	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.12.31
Эргэлтийн хөрөнгө	103,273,567	322,126,174	268,647,113	334,504,994
Эргэлтийн бус хөрөнгө	76,417,122	530,230,833	1,348,605,474	1,283,782,504
Нийт хөрөнгө	179,690,689	852,357,007	1,617,252,587	1,618,287,498
Богино хугацаат өр төлбөр	81,238,359	224,164,838	152,524,012	197,788,183
Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-
Нийт өр төлбөр	81,238,359	224,164,838	152,524,012	197,788,183
Эзэмшигчдийн өмч	98,452,329	628,192,168	1,464,728,575	1,420,499,315
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	179,690,689	852,357,007	1,617,252,587	1,618,287,498

Компанийн орлогын хураангуй тайлан, төгрөг

Орлогын үзүүлэлтүүд	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.12.31
Борлуулалтын орлого	155,719,573	268,486,227	312,663,010	474,905,307
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	39,895,117	168,908,674	84,679,757	95,126,634
Нийт ашиг/алдагдал	115,824,456	99,577,553	227,983,253	379,778,673
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	178,166	25,705	4,742,366	14,178,670
Үндсэн үйл ажиллагааны зардал	125,335,528	109,603,488	220,836,286	367,961,232
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6,435,210	10,865,527	-	-
ТТӨА/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,889,333	20,613,937
Татварын зардал	-	-	781,685	2,285,306
ТТДА/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,107,648	18,328,631
Ногдол ашиг	-	-	-	-
Цэвэр ашиг/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,107,648	18,328,631

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАВУУ ТАЛ, БОЛОМЖУУД (ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ)



ДАВУУ ТАЛ

- Үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ хэрэглэгчдэд танигдсан.
- Үнэт цаас гаргагчийн дата төвийн барилга, Дархан хот дах шинээр барих гэж буй Модуляр дата төв байрших газар нь үнэт цаас гаргагчийн өөрийн эзэмшлийнх учраас бусдаас хараат бус байх нөхцлийг бүрдүүлж байна.
- Чадварлаг боловсон хүчинтэй баг хамт олныг бүрдүүлсэн, Компанийн дотоод дүрэм журам, засаглал сайн.
- Компанийн санхүүгийн үзүүлэлтүүд жил бүр байнга өсч байгаа ба урт хугацааны өр төлбөргүй.
- Дамжуулан борлуулж буй бүтээгдэхүүнүүдийг багасгаж, өөрийн шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргаж эхэлсэн. 100% дотоодын бизнес и-мэйлийн үйлчилгээг 2016 оноос зах зээлд нэвтрүүлсэн.
- Өөрийн эзэмшлийн, олон улсын болон дотоодын стандартад нийцсэн үндсэн дата төвийг 2015 оноос ажиллуулж байна. Хүчин чадлыг нь 2016 онд 2 дахин нэмэгдүүлсэн.
- Интернэтийн үйлчилгээ үзүүлдэг зэргэлдээ компанитай.
- 2017 оны 9-р сард олон улсад мэдээллийн техноло-гийн салбарт тэргүүлэгч IBM корпорацийн Монгол Улс дахь албан ёсны төлөөлөгч болсон.
- Эхний жилүүдэд Модуляр дата төвийг холбох шилэн кабелийг түрээслэн ашиглах ба олон улсын транзит сүлжээний оператор болох Жемнэт ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан.



СУЛ ТАЛ

- Компанийн нөөц хязгаарлагдмал тул дэлхийн хамгийн өндөр стандартын технологи, тоног төхөөрөмжийг хараахан хэрэглэж чадахгүй байна.
- Дотоод хяналт, үйл ажиллагааны стандартын хэрэгжилт
- Зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулан борлуулдаг.
- Өмнө нь Модуляр дата төв угсарч ажиллуулж байсан туршлага байхгүй.



НӨӨЦ БОЛОМЖ

- Монгол орон цаг агаарын сэрүүн бүст оршдог тул дата төвийн үйл ажиллагаа эрхлэхэд нэн тохиромжтой.
- Салбарын хөгжил, өсөлт хурдацтай нэмэгдэж, мэдээллийн технологийн хэрэглээ өдөр өдрөөр нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо өсч байна.
- Төрийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого, дэмжлэг, хүчин чармайлт их байна. “Цахим засаглал” хөтөлбөр амжилттай хэрэгжиж, төрийн үйлчилгээ цахимжиж байна; үндэсний хиймэл дагуултай болсон.
- Төрөөс мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн талаар 2025 он хүртэл баримтлах бодлогыг боловсруулж байна. Тус бодлогод мэдээллийн аюулгүй байдлыг стратегийн нэг зорилго болгон онцолсон.
- 2016 оны 3-р сараас Улаанбаатар хот, хөдөө орон нутагт интернэтийн үйлчилгээний ижил үнэ тариф үйлчилж эхэлсэн ба хурдыг тодорхойлж өгсөн. Мөн, 2016 оны 4-р сараас үүрэн холбооны операторууд 4G LTE технологийг нэвтрүүлж эхэлсэн.
- Төрийн зохицуулах байгууллагуудаас банк, санхүү болон мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, учирч болох эрсдлийг бууруулах шаардлага тавигдаж эхэлсэн.
- Мэдээллийн технологийн хөгжлийг даган дэлхий нийтээрээ даяарчлагдсан тул, орон зай, цаг хугацаанаас үл хамааран, бага өртгөөр бүтээгдэхүүн импортлох, гаднаас хэрэглэгчдийг татах боломжтой.
- Салбарын өрсөлдөөн багатай байна. Модуляр дата төв одоогоор байхгүй.
- Одоогийн үйл ажиллагаатай уялдуулан зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой. /криптовалютын клауд майнинг үйлчилгээ г.м/



АЮУЛ ЗАНАЛ

- Эдийн засагт нүүрлээд байгаа хямралын нөлөө удаан хугацаагаар үргэлжилбэл хэрэглэгчийн худалдан авах чадвар, компанийн борлуултанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.
- Хамтран ажиллагч, нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас хамааралтай эрсдлүүд бий. /Сүлжээ, шилэн кабелийн тасралт, тэдгээрийн түрээсийн төлбөр нэмэгдэх, г.м./
- Валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан импортын бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн үнэ нэмэгдэх эрсдэлтэй.
- Дата төвийн эцсийн хэрэглэгчид, хөрөнгө оруулагчид мэдээллийн аюулгүй байдал, вэб байршуулах үйлчилгээний талаар сайн ойлголт мэдлэггүй.
- Дата төв ажиллуулахад шаардлагатай нарийн мэргэшлийн мэргэжилтнүүд цөөн.
- Гэнэт хүчтэй өрсөлдөгч гарч ирэх магадлалтай.
- Дата төв, байршуулах үйлчилгээг зохицуулсан эрх зүйн орчин тодорхой биш.



ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хэмжээнд үүрэн утас, интернэтийн хэрэглээ болон компьютерийн хэрэглээ жил ирэх тусам асар хурдацтайгаар өсч байна. 2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын хүн амын тоо 3 саяд хүрсэн ба үүрэн утас хэрэглэгчдийн тоо нь давхардсан тоогоор 5.56 саяд хүрч байгаа нь дунджаар нэг иргэнд 1.8 ширхэг утас оногдож байна. Мөн интернэт байнгын хэрэглэгчдийн тоо 2.4 сая байгаа нь 10-55 насныхан бүгд хэрэглэгч байж болохуйц харагдаж байна. Мөн Монгол Улсад бүртгэгдсэн компьютерийн тоо 2015 оны сүүлээр 581 мянган ширхэг байсан нь 3 хүн бүрийн дунд дунджаар 1 компьютер байгааг илтгэнэ.

Харилцаа холбооны салбарын хэрэглэгчдийн тоо



2016 оны эхний хагас жилийн байдлаар интернэт хэрэглэгчдийн 90.8 хувь нь 3G технологи ашиглан интернэтэд холбогдсон ба энэ нь ухаалаг утасны хэрэглээ өссөнтэй холбоотой байна. 2016 оноос 4G технологи нэвтэрч, хэрэглэгчид хамгийн багадаа 5-7 дахин илүүхурдаар хөдөлгөөнт өргөн зурвасын интернэтэд холбогдох боломжтой болсон. Ийнхүү интернэт хэрэглэгчийн тоо болон хурд нэмэгдэж байгаатай холбоотойгоор бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа илүү интернэт дээр тулгуурлан явуулах болсон нь дата төвийн эрэлт хэрэгцээг илүүтэй нэмэгдүүлж байна.

Тухайлбал, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа нийт байгууллагуудын 70 орчим хувь нь өөрийн гэсэн цахим хуудастай бөгөөд тус бүр 1Мбит/сек-10Мбит/сек хүртэл хурдтай интернэт

ашиглаж байгаа ба интернэт хэрэглэгчдийн 98 хувь нь шилэн кабель болон хөдөлгөөнт холбооны технологид суурилсан интернэтийн үйлчилгээ хэрэглэж байна¹.

Түүнчлэн, сүүлийн жилүүдэд төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, дэвшлийг Монгол улсын хөгжлийн хурдасгуур гэж үзэн, цахим засаг, цахим үнэмлэх, цахим боловсрол, цахим эрүүл мэнд зэрэг төсөл хөтөлбөрүүдийг шат дараалан хэрэгжүүлж байгаа билээ.

Ийнхүү интернэтийн үйлчилгээ, цахим мэдээллийн харилцаа өргөжихийн хэрээр мэдээллийн аюулгүй байдал, хадгалалтын асуудал чухлаар тавигдаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор төрийн зохицуулах байгууллагуудын зүгээс хууль журам, стандарт шаардлагуудыг батлан мөрдүүлж эхлээд байна.

¹ "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын төслийн танилцуулга

Тухайлбал, Монгол банкны зүгээс 2017 оны 6-р сарын 29-ний өдөр “Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам”-ыг батласан бөгөөд тус журмаар банкуудад харилцагчдын болон төлбөр тооцооны мэдээллийг аюулын өөр бүс буюу үндсэн төвөөс 200 км зайтай газар давхар хадгалах шаардлагыг тавиад байна. Үүнтэй адилаар цахим мэдээлэл үүсгэгчдэд, тэр дундаа бусдын мэдээллийг авч үйлчилгээ үзүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдээллийг найдвартай газар хадгалах, нөөцлөх шаардлага бодитоор тулгарч байгаа нь тусгай дата төвийн үйлчилгээг зүй ёсоор шаардаж байна.

Одоогоор Айтүүлс ХК-ийн үндсэн үйлчилгээ болох дата төвийн үйлчилгээг дагнан үзүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж Монголд цөөн байна. Үндэсний дата төв, Мобинэт ХХК зэрэг нь дата төвийн үйлчилгээ үзүүлдэг ч үйл ажиллагааных нь үндсэн зорилго, чиглэл өөр юм. Ихэнх байгууллагууд өөрсдийн дотоод хэрэгцээнд зориулж дата төв ажиллуулж байна.


Үндэсний дата төв УТҮГ	Мобиком корпораци /Мобинэт ХХК/	Датаком ХХК
<p>“Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар нь хүчин чадал, хамрах хүрээгээр одоогоор хамгийн том дата төвд тооцогддог ч үйл ажиллагааны үндсэн чиглэл нь зөвхөн төрийн байгууллагуудын цахим мэдээ мэдээллийг хадгалах, хамгаалах, боловсруулах юм. Хувийн хэвшилд үйлчилгээ үзүүлдэг ч маш хязгаарлагдмал ба цаашид төрийн үйлчилгээнд илүү анхаарах хандлагатай байна.</p> <p>Нөөц дата төвгүй.</p>	<p>Мобиком корпораци нь дата төвийн үйл ажиллагааг явуулдаг бөгөөд 2015 онд Дархан-Уул аймагт TIER III стандартыг хангасан газарзүйн нөөц дата төвийг шинээр ашиглалтанд оруулсан. Мобиком корпорацийн хувьд энэхүү газарзүйн нөөц дата төвийг өөрийн үндсэн үйл ажиллагаа болох үүрэн холбооны үйлчилгээний цахим мэдээ, мэдээллийг хадгалах, хамгаалах, боловсруулахад зориулан ашигладаг.</p> <p>Олон улсын сертификатгүй.</p>	<p>Датаком ХХК нь интернэтийн үйлчилгээг буюу домэйн нэрийн бүртгэл, цахим хуудас байршуулах үйлчилгээг Монголд анх нэвтрүүлсэн бөгөөд .mn домэйн нэрийн бүртгэлийн албан ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч юм. Датаком ХХК нь домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээг голлон үзүүлдэг бөгөөд дотооддоо дата төв байхгүй тул цахим хуудсыг гадаадад байршуулах, и-мэйлийн үйлчилгээг гаднаас авахад зуучилдаг.</p>



ЦАХИМ ХУУДАС БАЙРШУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Нийт зах зээлд эзлэх хувь

Дотоодын зах зээлд эзлэх хувь



Одоогоор Монгол цахим хуудаснуудын 62.3% буюу дийлэнх хэсэг нь гадаад дахь дата төвүүдэд байршиж буй бөгөөд сүүлийн үед цахим хуудас эзэмшигчид зардлаа бууруулах болон цахим хуудсанд нэвтрэх хурдаа нэмэгдүүлэх зорилгоор дотоодын дата төвүүдэд цахим хуудсаа байршуулах хандлагатай байгаа нь уг зах зээлийн хувьд маш чухал үзүүлэлт юм.



ҮНЭТ ЦААСЫГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь 2016 оны 11-р сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 14 тоот тогтоолоор Дархан хотод Модуляр дата төвийн парк байгуулахад зориулан олон нийтээс хөрөнгө татан, нээлттэй хувьцаат компани болохоор шийдвэрлэсэн. Улмаар 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 тоот тогтоолоор 13,387,980 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган, 100 төгрөгийн тогтоосон үнээр анхдагч зах зээлд санал болгож, нийт 1.3 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр тогтсон. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигчид нь үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй ба ингэснээр компани нийт хувьцааныхаа 38.86 хувийг олон нийтэд санал болгох юм.

Компанийн хувьцааг анх удаа олон нийтэд санал болгох үнийг 100 төгрөгөөр тогтоосон ба тогтоосон үнээр санал болгох аргаар арилжина. Хэрэв анхдагч зах зээлд олон нийтэд санал болгож буй тоо ширхгээс илүү захиалга ирвэл жижиг хөрөнгө оруулагчдыг идэвхтэй оролцуулах зорилгоор 50.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100 хувь биелүүлж, 50.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнг хувь тэнцүүлэн хуваарилна.


Хувьцааг олон нийтэд санал болгох үнийг тооцоолохдоо цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах аргаар тогтоосон компанийн бизнесийн үнэ цэнэ 4.4 тэрбум төгрөг дээр суурилсан. Түүнчлэн, нийт үнэлгээгээр нэгж хувьцааны үнэ 127.98 төгрөг гарсныг улс орны өнөөгийн эдийн засгийн зогсонги байдал, хөрөнгийн зах зээлийн идэвхийн түвшинг харгалзан, мөн олон нийтэд санал болгох хувийг нэмэгдүүлэх зорилгоор 22 хувиар бууруулж тогтоосон болно.



ХӨРВҮҮЛЭН ЭЗЭМШИХ ҮНЭТ ЦААС

Үнэт цаас гаргагч нь 13,387,980 ширхэг энгийн хувьцаа олон нийтэд санал болгож байгаа нь хувьцаа нэмж гаргасны дараах нийт хувьцааны 38.86 хувьтай тэнцүү ба компанийн одоогийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Ай Си Ти групп ХХК-ийн эзэмшлийн хувь 61.14 болж буурна. Компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар тогтсон.

Схем 4. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулахад хөрвөх хувьцаа



Хүснэгт 55. Хувьцаа эзэмшигчийн хөрвүүлэн эзэмших хувьцааны тоо, эзэмшлийн хувь

Хувьцаа эзэмшигчид	ХК болохоос өмнөх хувь эзэмшил		ХК болсны дараа (олон нийтэд санал болгосон хувьцаа 100% арилжигдвал)	
	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Ай Си Ти групп ХХК	21,064,144	100%	21,064,144	61.14%
Олон нийт			13,387,980	38.86%
Нийт	21,064,144	100%	34,452,124	100%



ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Олон нийтээс татан төвлөрүүлэхээр төлөвлөж буй 1.3 тэрбум төгрөгийг Дархан хотод Модуляр дата төвийн парк байгуулахад зарцуулна. Үнэт цаас гаргагчийн барих гэж буй Модуляр дата төв нь үйлдвэрлэгчээс дата төвийн үйлчилгээ үзүүлэх зориулалтаар урьдчилан инженерчлэгдэж тоноглогдсон контейнерэн дата модуль байна. Дата төвийн байнгын аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, аливаа гамшиг, гадны халдлагаас хамгаалагдсан орчныг бүрдүүлэхийн тулд паркийн барилга, бусад дэд бүтэц, тоног төхөөрөмж зэргийг олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх юм.



Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, төгрөгөөр

№	Хөрөнгө оруулалт	Нэгж	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг	Хувь
1	Паркийн барилга	900 м.кв	550,000	495,000,000	37.0%
2	Цахилгааны систем	1	120,000,000	120,000,000	9.0%
3	Хөргөлтийн систем	1	80,000,000	80,000,000	6.0%
4	Тоног төхөөрөмж	1	119,000,000	119,000,000	8.9%
5	Гадна дэд бүтэц	1	151,900,000	151,900,000	11.3%
6	Контейнер модуль	1	345,000,000	345,000,000	25.8%
7	Тавилга, эд хогшил	1	27,898,000	27,898,000	2.1%
Нийт дүн				1,338,798,000	100%



ХҮЛЭЭЖ БУЙ ҮР ДҮН

Шинээр байгуулах Модуляр дата төв нь олон улсын TIER III стандартыг шаардлагад нийцсэн, үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан, цогц үйлчилгээ бүхий орчин үеийн дата төв байна. Манай улс геополитикийн ач холбогдол бүхий байршилтай, байгалийн гамшиг, улс төрийн үймээн самуун зэрэг давагдашгүй хүчин зүйлс тохиолдох эрсдэл харьцангуй бага, цахилгаан эрчим хүч, интернэт, харилцаа холбооны үйлчилгээний үнэ бусад улстай харьцуулахад хямдад тооцогддог тул Модуляр дата төвийг цаашид олон улсын түвшний дата төв болгон хөгжүүлнэ.

Дотоодын хэрэглэгчдийн хувьд газарзүйн нөөц дата төвийн зориулалтаар ашиглахад нэн тохиромжтой бөгөөд нэг хэрэглэгч нэг модуль буюу контейнер ашиглах боломжтой тул зөөвөрлөн хэрэглэх, хүчин чадлаа хэрэгцээндээ тохируулан өсгөх, багасгах бүрэн боломжтойгоос гадна мэдээллийн нууцыг баттай хадгалах, гал ус, гадны аюул эрсдлээс сэргийлэн хамгаалах давуу талтай юм. Манай улсын хөгжил нийслэл хотноо төвлөрсөнтэй холбоотой төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд бүгд Улаанбаатар хотод мэдээллээ төвлөрүүлэн хадгалж байна. Хэрэв нийслэл хотод ямар нэгэн байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл тохиолдвол бүх цахим мэдээлэл алдагдах, улмаар байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдох, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл маш өндөр байгаа тул мэдээллийг газарзүйн нөөц дата төвд давхар байршуулах шаардлага өнөөгийн цахимжиж буй нийгэмд зайлшгүй тулгарч байгаа билээ.

Үүний нэг тод шаардлага нь Монгол банкны зүгээс 2017 оны 6-р сарын 29-ний өдөр "Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам"-ыг батласан бөгөөд тус журмаар банкуудад харилцагчдын болон төлбөр тооцооны мэдээллийг аюулын өөр бүсэд хадгалах, давхар ажиллуулах шийдлийг гаргаад байна.

Иймээс модуляр дата төвийн паркийг нийслэл хотоос 220 км-ийн зайд, газар хөдлөлийн харьцангуй аюулгүй бүст байршдаг Дархан хотод байгуулснаар энэхүү шаардлагыг хангахад хувь нэмэр оруулах юм.



МОДУЛЯР ДАТА ТӨВИЙН ДАВУУ ТАЛУУД

- Контейнерүүдийг давхарлан тавихаас авахуулаад, орон зай байвал дата төвийн хүчин чадлыг хүссэн хэмжээгээр нэмэх боломжтой.
- Нэг байгууллага зөвхөн өөрийн хэрэгцээнд зориулан нэг модуль/контейнер эзэмших эсхүл түрээслэх боломжтой тул мэдээллийн физик тусгаарлалт, нууцлалыг бүрэн хангах боломжтой.
- Өөр системүүдтэй холбогдон ажиллах, тохируулах боломжтой тул хэрэглэгчийн үндсэн дата төвтэй интеграцлагдах боломжтой.
- Эдийн засагт хэмнэлттэй, өртөг зардлын хувьд үр ашигтай. Үл хөдлөх хөрөнгийн болон ашиглалтын зардлыг хэмнэдэг.
- Эрчим хүч болон бусад нөөцийг илүү үр өгөөжтэй ашигладаг, байгаль орчинд ээлтэй.
- Суурилуулалтын үеийн болон суурилуулсны дараах үйлчилгээ үзүүлэх үед гарах алдаа бага. Үйлдвэрлэгчээс баталгаа өгдөг. Нэг модульд нэг стандартын гэрчилгээ олгож баталгаажуулдаг тул модулийг бүрдүүлдэг олон эд ангийг тус бүрт нь сертификатжуулахаас зайлсхийх боломжтой.
- Дэлхийн хаана ч тээвэрлэн, зөөж хэрэглэх боломжтой. Амархан угсрагддаг.

“Модуляр дата төвийн парк” төслийг хэрэгжүүлснээр үнэт цаас гаргагч нь 2017-2021 оны хооронд нийт 10.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 4.06 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, төслийн эцэст 4.99 тэрбум төгрөгийн ашиг хуримтлуулсан байхаар төлөвлөсөн. Төслийн хугацаан дах борлуулалтын орлого, зардал болон ашгийн үзүүлэлтийг дорх хүснэгтээр харуулав.


Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны орлогын төсөөлөл, мянган төгрөгөөр

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Үндсэн үйл ажиллагааны борлуулалт	616,821	832,708	1,082,521	1,380,214	1,725,268	5,637,532
Модуляр дата төвийн борлуулалт	246,000	743,400	1,098,090	1,403,042	1,473,194	4,963,725
Нийт борлуулалт	862,821	1,576,108	2,180,611	2,783,256	3,198,461	10,601,257
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	108,578	146,580	190,554	242,956	303,695	992,363
Нийт ашиг (алдагдал)	754,243	1,429,528	1,990,057	2,540,299	2,894,766	9,608,894
Үйл ажиллагааны зардал	578,769	766,324	844,338	913,513	957,101	4,060,043
Үйл ажиллагааны цэвэр ашиг/алдагдал	175,475	663,205	1,145,719	1,626,787	1,937,665	5,548,851
Татвар, 10%	17,547	66,320	114,572	162,679	193,767	554,885
Цэвэр ашиг (алдагдал)	157,927	596,884	1,031,147	1,464,108	1,743,899	4,993,966
Хуримтлагдсан цэвэр ашиг (алдагдал)	157,927	754,811	1,785,959	3,250,067	4,993,966	-

Жич: Дээрх төсөөлөл нь 2017 оны дунд үеэс Дархан хот дахь дата төвийг ашиглалтанд оруулахаар төлөвлөж хийгдсэн бизнес төлөвлөгөөн дээр үндэслэн хийгдсэн тул 2017 оны бодит үзүүлэлт төлөвлөснөөс доогуур байж болохыг анхаарна уу.




КОМПАНИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ӨСӨЛТ



Өнгөрсөн хугацаан дахь борлуулалтын орлогын дундаж өсөлт 95% байгааг аажмаар бууруулж 15% болгон тогтворжиж тооцооллыг хийсэн болно.

Бүтээгдэхүүний борлуулалтын өсөлт, сараар




Санхүүгийн үр ашгийн тооцоолол, шинжилгээ

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Нийт ахиуц ашиг	87.40%	90.70%	91.30%	91.30%	90.50%
Цэвэр ахиуц ашиг	18.30%	37.90%	47.30%	52.60%	54.50%
Үйл ажиллагааны ахиуц ашиг	20.30%	42.10%	52.50%	58.40%	60.60%
Татварын өмнөх ахиуц ашиг	20.30%	42.10%	52.50%	58.40%	60.60%
Нийт хөрөнгийн өгөөж	5.10%	17.10%	24.50%	28.00%	27.00%
Эздийн өмчийн өгөөж	5.50%	18.20%	25.70%	29.10%	27.90%

	2017	2018	2019	2020	2021
Нэгж хувьцааны өгөөж					
Эзэмшигчдийн өмч	2,917,224,402	3,514,108,569	4,545,255,984	6,009,364,074	7,753,262,844
Дансны үнэ	84.67	102	131.93	174.43	225.04
Нэгж хувьцаанд ногдох ашиг / EPS/, төгрөг	4.58	17.33	29.93	42.5	50.62
Үнэ ашгийн харьцаа, (P/E)	25.59	8.16	6.11	5.69	6.16
Үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцаа, (P/B)	1.39	1.39	1.39	1.39	1.39
Хувьцааны боломжит зах зээлийн үнэ, төгрөг	117.3	141.3	182.76	241.63	311.75
Боломжит зах зээлийн үнэлгээ, төгрөг	4,041,234,145	4,868,098,433	6,296,548,071	8,324,778,604	10,740,603,472
Боломжит ханшийн өсөлт	17.30%	20.50%	29.30%	32.20%	29.00%
Боломжит ханшийн өгөөж	3.90%	12.30%	16.40%	17.60%	16.20%
Анхны хөрөнгө оруулалтын өгөөж	17.30%	41.30%	82.80%	141.60%	211.80%

Компанийн цэвэр ашгийн өсөлтийн төсөөлөл, сая төгрөгөөр



Жич: Дээрх төсөөлөл нь 2017 оны дунд үеэс Дархан хот дахь дата төвийг ашиглалтанд оруулахаар төлөвлөж хийгдсэн бизнес төлөвлөгөөн дээр үндэслэн хийгдсэн тул 2017 оны бодит үзүүлэлт төлөвлөснөөс доогуур байж болохыг анхаарна уу.



ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ

- Айтүүлс ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн бирж 2017 оны 5-р сарын 15-ны өдөр MSE:ITLS гэсэн үсгэн кодоор /тоон код 543/ бүртгэсэн ба Санхүүгийн зохицуулах хороо 2017 оны 9-р сарын 27-ны өдрийн 173 тоот тогтоолоор бүртгэсэн.
- Та MSE: ITLS хувьцаанаас худалдан авахын тулд нэн түрүүнд хувьцааны данс нээлгэсэн байна. Зөвхөн үнэт цаасны арилжаа хийгддэг зориулалтын энэхүү дансыг өөрийн сонгосон үнэт цаасны компаниар дамжуулан нээлгэнэ. Та брокероо сонгож амжаагүй бол Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаснаас гишүүн үнэт цаасны компаниудын жагсаалт руу орж сонгоорой.
- Худалдан авах хувьцааны тоог брокертоо мэдэгдэж, захиалгаа өгнө. Захиалгын хуудсанд гарын үсэг зурахаа мартуузай.
- Та захиалгаа өгмөгц дансандаа мөнгө байршуулна. Арилжааны шимтгэлийг тооцоолж, мөн дансныхаа дугаарыг өөрийн брокероос лавласны үндсэн дээр мөнгөө 100 хувь урьдчилан байршуулснаар таны захиалга хүчин төгөлдөр болно.
- Та зөвхөн хувьцааны тогтоосон үнэ болох 100 төгрөгөөр захиалга өгч болох ба 50 сая хүртэлх захиалга эхэнд биелэгдэнэ.
- Захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давсан тохиолдолд 50 сая төгрөгөөс дээш давсан дүнг хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилна.
- Анхдагч зах зээлийн арилжаа явагдаж, хувьцааны нийлүүлэлт хийгдсэний дараа таны захиалгын биелэлтийг брокер мэдэгдэнэ.
- Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг олгосноор хувьцаагаа хуулийн дагуу захиран зарцуулах эрх Танд үүснэ.

ХУВЬЦААНЫ МӨНГӨ БАЙРШУУЛАХ ЗААВАР

1. Дотоодоос мөнгө байршуулах

Хүлээн авах банк: Арилжааны төлбөр тооцоо ХХК

Хүлээн авагчийн нэр: Таны овог нэр

Хүлээн авагчийн дансны дугаар: 0***000* ****

Энхий 4 орон Дараагийн 8 орон таны АТТ/
ҮЦК-ийн код байна. ҮЦТХТ дэх дансны дугаар байна.

12 оронтой дугаар байна. Орон хүрэхгүй бол 0-ээр дүүргэж өгнө. Ж нь: 100-1111 дугаартай харилцагч 0100 0000 1111 болно. АТТ/ҮЦТХТ дэх өөрийн дансны дугаарыг брокероосоо авна уу.

Гүйлгээний утга: Хувьцааны мөнгө /харилцах утасны дугаарыг бичих/

2. Гадаадаас мөнгө байршуулах

Beneficiary: Securities Settlement Clearing House

Beneficiary's Account No: 1021 0055 0293

Beneficiary Bank: State Bank of Mongolia

SWIFT Code: STBM MN UB

Description: Your full name, registration number & account number

These are your registration and account number at the Central Depository. Please ask your broker for these numbers.

АНДЕРРАЙТЕРИЙН НӨХЦӨЛ



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот

Утас/Факс: 7011-4433

И-мэйл: info@standardinvestment.mn

Вэбсайт: www.standardinvestment.mn

Стандарт инвестмент ҮЦК нь 2016 оны 11-р сарын 21-ний өдөр Айтүүлс ХХК-тай андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан ба гэрээнд заасны дагуу "Үнэт цаас гаргагчийн хувьцааг дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах" нөхцлөөр ажиллана. Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 75%-ийг анхдагч зах зээлд арилжаалсан тохиолдолд IPO-г амжилттай болсонд тооцохоор тогтоосон.

ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Үнэт цаас гаргагчийн хөрөнгө, санхүүгийн байдал, үйл ажиллагаа, бизнесийн төлөвлөгөөг Санхүүгийн зохицуулах хорооноос хүлээн зөвшөөрсөн, тусгай зөвшөөрөл бүхий, хараат бус мэргэжлийн байгууллагууд болох Сүлд Аудит ХХК, Атен ХХК, Өмгөөллийн Монгол зарга ХХН хянаж, хөндлөнгийн тайлан, дүгнэлтүүдийг гаргасан.



Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, 45А байр, 2 давхар, 202, 203 тоот

Утас/Факс: 7700-4445

И-мэйл: info@mongolzarga.mn

Вэбсайт: www.mongolzarga.mn



Хаяг: Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 2-р 40 мянгат, Пума ХХК-ийн байр

Утас/Факс: 9904-0051, 99080050

И-мэйл: aten_company@yahoo.com

Эдгээр байгууллагууд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнууд нь хоорондоо нэгдмэл сонирхолгүй ба андеррайтер Стандарт инвестмент ҮЦК ХХК-аас бусад нь үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтнуудтай нэгдмэл сонирхолгүй болно.

**ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН
ШИНЭ ҮЙЛЧИЛГЭЭ**



Үнэт цаас гаргагч Айтүүлс ХК нь 2017 оны 9-р сард дэлхийн мэдээллийн технологийн тэргүүлэгч компаниудын нэг болох IBM корпорацийн Монгол улс дахь албан ёсны төлөөлөгч болов.



Mining farm буюу тоног төхөөрөмжийг байршуулах, түрээслэх үйлчилгээг 2017 оны 10-р сараас нэвтрүүлж эхэллээ.



Дэлхий даяар 22 датацентрийн сүлжээтэй Австрали улсын RackCorp групптэй хамтын ажиллагааны чиглэл гаргалаа.



ЭРСДЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Хувьцаанд хөрөнгө оруулах нь ямагт эрсдэлтэй байдаг тул дор дурдсан эрсдлийн хүчин зүйлстэй сайтар уншиж танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Дор дурдсан эрсдлийн хүчин зүйлсээс гадна үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлж болох өөр эрсдлүүд үүсэх боломжтойг анхаарна уу.

Төрийн бодлого, улс төрийн нөхцөл байдалтай холбоотой үүсэх эрсдэл

Мэдээллийн технологийн салбарт төрөөс баримталж буй одоогийн бодлого, чиглэлд өөрчлөлт орох эрсдэлтэй. Тиймээс мэдээллийн технологийн салбарыг дэмжсэн одоогийн хөтөлбөр, төслийн хэрэгжилт нь сонгуулийн дараа, эсвэл засгийн газар солигдох зэргээс шалтгаалан өөрчлөгдвөл үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлнө.

Бизнесийн салбар, эдийн засгийн эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд макро болон микро эдийн засгийн тогтворгүй байдал, хямрал сөргөөр нөлөөлнө. Тухайлбал, дараах нөхцөл байдал үүсэх нь эрсдэл дагуулна. Үүнд:

- Төсөв, мөнгөний бодлого өөрчлөгдөх
- Валютын ханшийн тогтворгүй байдал
- Үнийн өсөлт, инфляци
- Ажилгүйдлийн түвшин
- Түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзэл, нийлүүлэлт багасгах
- Бүтээгдэхүүний эрэлт багасч, үнэ буурах

Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл

Мэдээллийн технологийн салбарын дэд бүтэц болох дата төвийн үйл ажиллагаа нь өндөр технологитой учир мэргэшсэн боловсон хүчин, технологийн нарийн ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм журмууд, тэдгээрийн хэрэгжилтээс компанийн хэвийн ажиллагаа ихээхэн

шалтгаалдаг. Үнэт цаас гаргагчийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ харилцагчдад борлуулсны дараа үйл ажиллагааг нь доголдуулахгүйн тулд үйлчилгээгээ байнга, тасралтгүй хэвийн явуулахыг шаардсан өндөр хариуцлага хүлээдэг.

Техник, технологитой холбоотой эрсдэл

Техник, технологийн хөгжил асар хурдацтайгаар урагшилж байгаа өнөө үед мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт техник, технологийн хоцрогдол нь үйл ажиллагааны бүтээмж, зах зээлийн өрсөлдөх чадварыг бууруулах гол хүчин зүйлд тооцогддог.

Өрсөлдөгчидтэй холбоотой эрсдэл

Мэдээллийн технологийн салбарын дэд бүтэц болох дата төвийн чиглэлээр үнэт цаас гаргагчтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагууд одоогоор харьцангуй цөөн байгаа ч цаашид шинээр өрсөлдөгчид зах зээлд орж ирэх бүрэн боломжтой юм.

Санхүүгийн эрсдэл

Санхүүгийн эрсдэлд төслийн санхүүжилтийн мөнгөн урсгал, гадаад валютын ханшийн хэлбэлзэл, тоног төхөөрөмж болон ажил үйлчилгээний үнийн хэлбэлзэл, мэдээллийн технологийн үйлчилгээний үнийн хэлбэлзэл, цаг хугацаатай холбоотой компанийн ашигт ажиллагаанд нөлөөлж болох аливаа эрсдэл орно.

ДАТА ТӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Өнөөдөр таны дансан дахь мөнгө, эзэмшиж буй хувьцаа, өдөр тутам мэдээлэл авдаг сайтууд, и-мэйл, интернэтээр сонсож буй дуу, үзэж буй кино, төрийн байгууллагуудаас олгож буй лавлагаа зэрэг та бидний өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсон маш олон зүйл бол аль нэг дата төвд хадгалагдаж буй дата буюу цахим мэдээлэл, өгөгдлүүд юм. Өөрөөр хэлбэл та бидний өдөр тутмын амьдрал дата төвүүдэд хадгалагдаж буй мэдээлэл буюу дата дээр тогтон үргэлжилдэг бөгөөд энэ хамаарал цаг минут тутамд нэмэгдсээр байна.

Ийнхүү мэдээллийн технологийн гүйцэтгэх үүрэг, мэдээллийн тоо хэмжээ өсөхийн хэрээр энэхүү мэдээллийг аюулгүй хадгалах, үйл ажиллагаандаа тасралтгүй ашиглах хэрэгцээ нэмэгдсэн нь дата төвийн ач холбогдлыг өсгөж байна. Мэдээллийн технологийн өгөгдлүүдийг тусгай зориулалтын тоног төхөөрөмжүүд дээр хадгалах, шаардлагатай үед нөхөн сэргээх үйлчилгээг дата төвүүд гүйцэтгэдэг. Дата төв нь харилцагчийн мэдээллийн аюулгүй, тасралтгүй байдлыг хангахын тулд нөөц цахилгааны систем, сүлжээ, аюулгүй байдал, хамгаалалтын системээр тоноглогдсон байдаг.

Өнөөдөр Та NEWS.MN-ээс мэдээлэл уншиж, E-MART-аас худалдан авалт хийж, BUSINESS MAIL-ийг ашиглаж, ТЭС ПЕТРОЛИУМ-ын картаар хөнгөлөлттэй шатахуун авч, Hi-Fi Stream-ээс онлайнаар дуу сонсож үзсэн бол Айтүүлс ХК-ийн дата төвөөр аль хэдийн үйлчлүүлсэн гэсэн үг.

Үнэт цаасны зах зээлтэй холбогдон үүсч болох эрсдэл

Үнэт цаасны зах зээлтэй холбоотой эрсдэлд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжүүлэлт, санхүүжилт босгохтой холбоотой эрсдлүүдийг дурдаж болно. Үүнд, хөрөнгийн зах зээлээс татахаар төлөвлөсөн хөрөнгийг татаж чадахгүй байх, зах зээлд гаргасан хувьцааны үнийн хэлбэлзэл, арилжааны идэвх, хөрвөх чадвар муу байх асуудлууд орно.

Давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл

Газар хөдлөлт, хөрсний гулгалт, үер гэх мэт байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн гэх мэт онцгой байдал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Иймд үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц бүх нөхцөл байдлыг урьдчилан тооцоолж сэргийлэх, давагдашгүй хүчин зүйл тохиох үед хамгаалах тодорхой нөөц хэрэгсэл, гамшигт үзэгдлийн үед авах арга хэмжээ, хохирлыг бууруулах арга замуудыг төлөвлөсөн бэлэн байдлын бодлоготой байх нь чухал.

Аюулгүй байдлын эрсдэл

Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй бизнест аюулгүй байдал чухал ач холбогдолтой. Дата төвийн үйл ажиллагаа 24 цагийн турш тасралтгүй байх шаардлагатай, мөн төвд харилцагчдын дотоод чухал болон нууц мэдээлэл байршдаг тул найдвартай, аюулгүй байдлыг дээд зэргээр хангах шаардлагатай юм. Дата төвөөс мэдээлэл алдагдах, үйл ажиллагаа нь гадны санаатай болон санамсаргүй халдлагаас болж тасалдах эрсдэл байдаг. Эдгээрээс урьдчилан сэргийлэхийн тулд хяналт, хамгаалалтын сайн тогтолцоо бий болгох нь чухал юм.

Үнэт цаасны дэлгэрэнгүй танилцуулгатай дараах хаягаар орж танилцана уу.

- www.itools.mn
- www.standardinvestment.mn
- www.mse.mn



Андеррайтер

“Стандарт инвестмент ҮЦК” ХХК
70114433, 99072694, 99072783
broker@standardinvestment.mn
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Жигжиджавын гудамж, 5/3 тоот

Үнэт цаас гаргагч

“Айтүүлс” ХК
75755585, 99078211
info@itools.mn
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Амарын гудамж-22, 7/А тоот